



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2023.4.19 № ЦАТ-11/03/070

танай 2023.3.21-ний № 23/81-т

Г Агентын өөрчлөлтийн тухай 7

Танай компаниас ирүүлсэн нэр бүхий гурван агентыг бүртгүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.7-д “Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 3 агент (Батнасангийн Янжмаа, Батчулууны Билэгт, Батсүхийн Дөлгөөн нар)-ыг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох бүртгэлд нэмж, өөрчлөлтийг хийсэн болохыг мэдэгдье.

Дээрх журмын 6.5-д “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ.” гэж заасны дагуу агентын өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж ажиллахыг зөвлөж байна.

